

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ,  
СУМДЫН 2023 ОНЫ 02 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2023.03.03

Сүхбаатар сум

**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:**

**Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:**

Төрийн захиргаа, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, газар тариалан, боловсрол, эрүүл мэнд, хууль хяналт, хил хамгаалах байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан Сэлэнгэ аймгийн харьяат хүмүүсийг Монгол Улсын одон медалиар шагнасныг Улсын Их Хурлын гишүүн Ж.Эрдэнэбат, Ч.Ундрэм, Д.Өнөрболор аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж, аймгийн Засаг даргын орлогч Ж.Сайнцог нар гардуулан өглөө.

Тус арга хэмжээний хүрээнд манай аймгаас “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор 5, “Цэргийн гавьяаны одон”-оор 1, “Алтан гадас одон”-оор 33, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар 11, “Соёлын тэргүүний ажилтан”-аар 3, “Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний тэргүүний ажилтан”-аар 1, “Эрчим хүчний яамны жуух бичиг”-ээр 1 иргэн тус тус шагнууллаа.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаар “Улсын аварга малчин”, “Улсын хошой аварга малчин”, “Улсын аварга саальчин”, “Улсын аварга фермер”, “Улсын аварга тариаланч”, “Улсын аварга тариаланч” хамт олныг шалгарууллаа.

**“Улсын аварга малчин”-аар:**

1. Зүүнбүрэн сумын Мангирт багийн малчин Буякагийн Жаргалсайхан
2. Баруунбүрэн сумын Бургалтай багийн малчин Мягмарын Элдэв-Очир

**“Улсын аварга фермер”-ээр:**

1. Алтанбулаг сумын Бүргэдэй багийн фермер Дэлгэрмаагийн Мөнхбадрах

**“Улсын аварга тариаланч хамт олон”-оор:**

1. Цагааннуур сумын “Ургацын хишиг” ХХК
2. Орхон сумын “Мөнх-Орхон” ХХК
3. Хушаат сумын “Элит-үр” ХХК, “Арсэвд могойт” ХХК, “Өгөөжмандал уул” ХХК

**“Улсын аварга тариаланч”-аар:**

1. Орхон сумын тариаланч Сумъяагийн Сүхбаатар
2. Цагааннуур сумын “Шаргалтариа” ХХК-ий механикжуулагч Догсомын Ганбат
3. Орхонтуул сумын “Орхон тариа” ХХК-ий механикжуулагч Батсуурийн Батдорж нар тодорчээ.

Мөн аймгийн Засаг даргын 2023 оны А/41 дүгээр захирамжаар 2022 оны ажил үйлсээрээ тэргүүлсэн аймгийн аваргуудаа тодрууллаа.

**“Аймгийн аварга малчин”-аар:**

1. Алтанбулаг сумын малчин Жамъянгийн Алтангэрэл
2. Баруунбүрэн сумын малчин Мягмарын Эрэмжээ
3. Баруунбүрэн сумын малчин Бүдээгийн Лувсанхүү
4. Баянгол сумын малчин Чимэддоржийн Даваасүрэн
5. Баянгол сумын малчин Шагдарсүрэнгийн Батдаваа
6. Баянгол сумын малчин Цээпилийн Гомбожав

7. Жавхлант сумын малчин Цэвээний Бямбадорж
8. Зүүнбүрэн сумын малчин Доржийн Дорлиг
9. Зүүнбүрэн сумын малчин Нинжийн Батцоож
10. Зүүнбүрэн сумын малчин Доржийн Цагаанхүү
11. Мандал сумын малчин Маналжавын Бадамдорж
12. Орхон сумын малчин Галиндэвийн Түмэнбаяр
13. Орхон сумын малчин Дугарын Хүрэлбаатар
14. Орхонтуул сумын малчин Жаргалын Чимэдцэрэн
15. Орхонтуул сумын малчин Дамирангийн Баатархүү
16. Орхонтуул сумын малчин Дорлигийн Даваадорж
17. Сайхан сумын малчин Жамсрангийн Даваа
18. Сайхан сумын малчин Төмөрийн Эрдэнэбат
19. Сант сумын малчин Банзрагчийн Ганбат
20. Хүдэр сумын малчин Магнайгийн Батцэнгэл
21. Түшиг сумын малчин Яншийгийн Юндэндорж
22. Хушаат сумын малчин Гүндэвийн Адъяахүү
23. Хушаат сумын малчин Жамъянгийн Намдаг
24. Цагааннуур сумын малчин Буйманжавын Тэгшээ
25. Шаамар сумын малчин Нямхүүгийн Тогтохбаяр

“Аймгийн аварга фермер”-ээр:

1. Алтанбулаг сумын фермер Яваахүүгийн Буянжаргал
2. Баянгол сумын фермер Лувсанжамъянгийн Эрдэнэбаяр
3. Мандал сумын фермер Цэдэвийн Төмөрхуяг
4. Хушаат сумын фермер Тэгшээгийн Пүрэвсүрэн
5. Мандал сумын фермер Монхоодойн Батболд
6. Алтанбулаг сумын фермер “Хүчү Агро” ХХК

“Аймгийн аварга тариаланч”-аар:

1. Хүдэр сумын тариаланч Бадарчийн Цэгмэд
2. Цагааннуур сумын тариаланч Галбаатарын Пүрэвбаатар
3. Цагааннуур сумын тариаланч Чимэдбалжирын Чимэддорж
4. Цагааннуур сумын тариаланч Баярнэмэхийн Чойжамц
5. Хушаат сумын тариаланч Жанцангийн Отгондорж
6. Ерөө сумын тариаланч Хишигбаярын Азбаяр нар ажил үйлсээрээ манлайллаа.

Аймгийн “Удирдах ажилтны зөвлөгөөн”-ийг зохион байгууллаа. Зөвлөгөөнд Улсын Их Хурлын гишүүн Ж.Эрдэнэбат, Шинэ сэргэлтийн бодлогын “Хурдасгуур төв”-ийн захирал Б.Дөлгөөн, Мэдээлэл, дүн шинжилгээний хэлтсийн дарга Ч.Алтан-Өлзий, “E-Mongolia Академи”-ийн Процесс аналит хариуцсан захирал Г.Будням, “Менторшип” сургалтын удирдагч багш доктор Ц.Бүжидмаа, Удирдлагын академийн улсын салбарын удирдлагын тэнхимийн багш доктор П.Оюун-Эрдэнэ нар оролцож, илтгэл мэдээлэл хүргэлээ.

Зөвлөгөөний үеэр төр, засгийн бодлого, шийдвэрийг бүтээлчээр хэрэгжүүлж, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмэр, “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, Монгол Улсын Засгийн газар, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн зорилтыг хариуцсан

салбартаа амжилттай хэрэгжүүлсэн 2022 оны аймгийн аварга байгууллага, сум, тосгон, ОНӨААТҮГ болон ажилтнуудаа тодруулан шагнаж, урамшууллаа.

Аймгийн тэргүүний байгууллагаар:

1. Улсын бүртгэлийн хэлтэс
2. Биеийн тамир, спортын газар
3. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
4. Стандарт, хэмжил зүйн хэлтэс
5. Мал эмнэлгийн газар

Төрийн үйлчилгээний тэргүүний байгууллагаар:

1. Аймгийн Нэгдсэн музей

Аймгийн тэргүүний сумдууд:

1. Цагааннуур сум
2. Ерөө сум
3. Сант сум
4. Түшиг сум
5. Жавхлант сум

Аймгийн тэргүүний тосгоноор:

1. Ерөө сумын Бугант тосгон

Аймгийн тэргүүний орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар:

1. “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ тус тус ажил үйлсээрээ манлайллаа.

Мөн уг зөвлөгөөнөөр төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж буй анхан шатны нэгж болох 17 сумын Засаг дарга Тамгын газар, багийн Засаг дарга нарын үйл ажиллагааг дэмжин нийт 75 ширхэг зөөврийн компьютерыг гардуулан өглөө.

Аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж Мандал сумын Минжийн хангай 7 дугаар багийн иргэн С.Эвлэлд 5 ханатай өргөө цагаан гэр хүлээлгэн өглөө.

Мөн аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж болон аймгийн удирдлагын багийн зүгээс эрүүл мэндийн салбарт онцгой анхаарал хандуулан хүн ам ихтэй өв суурин буюу аймгийн төвийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын эмнэлэг, Сайхан сумын эмнэлгүүдэд хөрөнгө оруулалтын ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэн Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн дэргэд “Эрүүл мэндийг дэмжих төв” байгуулахаар болж эхний ээлжид Сэлэнгэ аймгийн Засаг дарга Эрүүл мэндийн сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд 500 орчим сая төгрөгийн 16 нэр төрлийн тоног төхөөрөмж нийлүүлээд байна.

Аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж Канад Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Катрин Ивкофыг хүлээн авч уулзаж, Сэлэнгэ аймгийн гадаад харилцааг хөгжүүлэхэд онцгой анхаарч байгаагаа илэрхийлээд хамтран ажиллах талаар санал солилцлоо.

Аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж Монголын хөл бөмбөгийн холбооны удирдлагуудыг хүлээн авч уулзан санал солилцож, хөл бөмбөгийн спортыг дэмжиж ажиллахаа илэрхийллээ. Уулзалтад Сэлэнгэ аймгийн хөл бөмбөгийн спортын хөгжилд хувь нэмрээ оруулж яваа ахмад тамирчдын төлөөлөл оролцлоо.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын хамт олон, Батлан хамгаалах зарим чиг үүргийг орон нутагтаа хэрэгжүүлэн, ажил үйлсээрээ манлайлан ажиллаж 2022 оны “ТЭРГҮҮНИЙ ЦЭРГИЙН ШТАБ”-аар шалгарлаа.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, “Хот, хөдөөгийн сэргэлт” ажлын хэсэг, НҮБ-ын Шилжилт хөдөлгөөний байгууллага хамтран Орон нутагт шилжин суурьших боломж шилжилт хөдөлгөөний бүсийн хэлэлцүүлгийг Дархан-Уул аймагт зохион байгуулж, хэлэлцүүлэгт аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж тэргүүтэй төлөөлөл оролцож Улаанбаатар хотоос манай аймагт шилжин суурьшсан “Сүүтэй” ХХК-ий захирал Д.Гэрэлчимэг “Орон нутгийн хөгжил шилжин суурьшигчийн нүдээр” сэдвээр илтгэл тавилаа.

**Онцгой байдлын ажил үйлчилгээний талаар:**

Тайлант хугацаанд объектын гал түймрийн 7, аврах ажиллагааны 1 нийт 8 удаагийн гамшиг осол, гал түймрийн дуудлагаар гарч иргэн, аж, ахуйн нэгж байгууллагын 225 сая төгрөгийн өмч хөрөнгийг гал түймэр, гамшиг ослын аюулаас авран хамгаалсан.

Онцгой байдлын газрын даргын баталсан “Сар шинэ-2023” нэгдсэн арга хэмжээний удирдамжийн дагуу Сүхбаатар, Мандал, Баянгол, Сайхан суманд үйл ажиллагаа явуулж буй 18 иргэний гэр, байшингийн галын аюулгүй байдлыг хангуулах хяналт, шалгалтыг хийж нийт 51 зөрчлийг илрүүлж, үзлэг шалгалтын явцад 7 зөрчлийг арилгуулан, бусад 44 зөрчлийг арилгуулахаар Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх мэдэгдлийг гаргаж айл өрхөд өгч ажиллалаа.

Төрийн болон төрийн бус байгууллагуудад “Цагаан сар” баяр амралтын өдрүүдэд галын аюулгүй байдалд хяналт тавих үүрэг бүхий хариуцлагатай эргүүл жижүүрийг тухайн байгууллагын галын сайн дурын бүлгэмийн гишүүдээс томилж, галын аюулгүй байдлыг ханган ажиллах, заавар, зөвлөмж өгч, Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн мэдэгдэл 12 аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад өгч ажиллалаа.

Төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар Мандал суманд үйл ажиллагаа “Тэсрэх бодисын түр агуулах”-д зохион байгуулан илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч болон гал түймрийн улсын хяналтын байцаагч нар заавал биелүүлэх албан шаардлага 3-ыг үйлдэн байгууллагын захирал нарт гардуулан ажилласан.

**Үзлэг шалгалтын явцад боловсруулсан нийт эрх зүйн бичиг баримт**

Үзүүлэлт Он	Шалгалтад хамрагдсан		Зөрчил		Бичсэн эрх зүйн бичиг баримт						Хянасан зураг төсөл	Улсын комисст
	ААНБ	Айл өрх	илрүүлсэн	Арилгуулсан	ЗБАШ	Мэдэгдэл	Танилцуулга	Дүгнэлт	Акт	АЗТогтоол		
2023.02	66	263	196	15	25	31	-	-	5	1	4	-

Орхон, Ерөө голын эрэг орчим мөсөн дээгүүр зорчсон 142 машин болон 498 иргэдийг бүртгэн, иргэдэд мөс цөмрөх аюулаас урьдчилан сэргийлэх материал тарааж, “Хараа гол”-ын эрэг дагуу мөс цөмрөх эрсдэл бүхий аюултай гармуудад сэрэмжлүүлэг самбар 4-ийг байрлуулж ажилласан.

Онцгой байдлын газрын даргын баталсан “Мөс цөмрөх аюулаас урьдчилан сэргийлье!” нэгдсэн арга хэмжээний хүрээнд 3 төрлийн сэрэмжлүүлэг шторк бэлтгэж, байгууллагын цахим хуудсанд байршуулж иргэд олон нийтэд хүргэн ажилласан.

Цаг агаарын урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг багц мессежийг 3 удаагийн давтамжтайгаар 210 хүнд нийт 360 удаа сэрэмжлүүлэг хүргэж ажилласан.

**Стандарт, хэмжил зүйн үйл ажиллагааны талаар:**

**Үйлчилгээний баталгаажуулалт:** Сүхбаатар, Мандал, Алтанбулаг, Хүдэр, Шаамар сумдын 9 аж ахуйн нэгж, иргэний үйлчилгээний газрыг тохирлын үнэлгээнд хамруулж “Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5021-1:2019 стандартын шаардлагыг хангасан 8 хүнсний дэлгүүрт тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаатай олголоо, 1 үйлчилгээний газар нь стандартын шаардлага хангаагүй тул тохирлын гэрчилгээ олгогдоогүй байна

**Экспорт баталгаажуулалт:** Ерөө суманд төмрийн хүдэр олборлодог 2 аж ахуй нэгжийн төмрийн хүдэрт “Металлургид хэрэглэх төмрийн хүдэрт тавих ерөнхий шаардлага ба төмрийн хүдрийг орлох түүхий материалын ангилал- MNS 6249 : 2011” стандартын дагуу тохирлын үнэлгээ хийж, 58 ширхэг экспортын тохирлын гэрчилгээ олголоо.

Стандарт, мэдээллийн салбар сангаас 9 аж ахуй нэгж, байгууллага иргэний захиалгын дагуу 6 нэрийн 10 стандартын борлуулалт хийж, мэдээлэл арга зүйн зөвлөмж өгч ажилласан.

Сүхбаатар сумын худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаанд “Хэмжилзүйн тухай” хуулиудын хэрэгжилтийг хангуулах үүднээс ашиглагдаж буй хэмжих хэрэгслийг баталгаажуулалтад хамруулах ажлыг хийсэн.

**Эзлэхүүн хэмжлийн төрлөөр:** 2 аж ахуйн нэгжийн хүсэлтийн дагуу ээлжит бус шалган баталгаажуулалт хийлээ. Үүнд: Цагааннуур суманд шинээр ашиглалтад орж байгаа Шатахуун түгээх газрын 3 хэмжих хэрэгслийг, Сүхбаатар сумын “Жаст” ШТС-ын дизелийн түлшний түгээгүүрийг шалган баталгаажууллаа.

**Шалган тохируулгаар:** 2 байгууллагын 2 лабораторийн 2 жин, 8 шилэн хэмжүүр, пипеткад шалгалт тохируулга хийлээ.

**Массын хэмжлээр:** Худалдаа үйлчилгээнд ашиглагдаж байгаа 57 жин, Хөдөө, аж ахуйн дэмжих сангийн Сэлэнгэ салбар болон, Түшиг суманд үйл ажиллагаа явуулдаг “Рид хилл Монголия” ХХК-ий автомашины пүүг шалган баталгаажуулсан байна.

**Дулаан даралтаар:** 4 аж ахуйн нэгжийн 22 ш термометр, 2 манометр, 3 цусны даралтын аппарат шалган баталгаажууллаа.

Итгэмжлэгдсэн лабораториор 9 аж ахуйн нэгжийн 7 нэр төрлийн 27 дээжид 83 үзүүлэлтээр сорилт шинжилгээ хийснээс 1 аж ахуйн нэгжийн 1 дээж 1 үзүүлэлтээр эерэг үр дүнтэй гарсан байна.

**Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:**

1 сард 736 баримтаар 10,2 тэрбум төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэлээ.

Аймгийн 01 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн мэдээг гаргаж Статистикийн хэлтэст хугацаанд нь хүргүүлж, мөн сарын аймгийн орлогын гүйцэтгэлийн мэдээг Татварын хэлтэстэй тулган баталгаажуулж, төсвийн

гүйцэтгэлийн мэдээг сар бүр аймгийн цахим хуудас, шилэн данс болон ил тод байдлын самбарт байршуулан ажиллаж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг сум бүрд хуваарилан тавьж, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт олгосон.

### 1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
<b>1</b>	<b>Орон нутгийн төсвийн нийт орлого</b>	<b>9,926,307.2</b>	<b>3,174,705.7</b>	<b>32.0</b>
	Орон нутгийн төсвийн орлого	3,663,539.8	2,631,461.8	71.8
1.1	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	1,1574,907.4	304,320.7	19.3
	Сумдын төсвийн орлого	2,088,632.4	2,327,141.1	111.4
1.2	Сумдаас авах орлогын шилжүүлэг	543,243.9	543,243.9	100
1.3	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	400,000	-	-
1.4	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	3,823,015.9	-	-
1.5	Хандив /Орон нутгийн хөгжлийн сан/	-	-	-
1.6	Төсөвт байгууллагын өөрийн орлого	636,267.9	-	-
1.7	Сум хөгжүүлэх сангийн орлого	860,239.7	-	-
<b>2</b>	<b>Орон нутгийн төсвийн нийт зарлага</b>	<b>9,926,307.2</b>	<b>3,359,616.2</b>	<b>33.8</b>
	Орон нутгийн төсвийн нийт зарлага	9,926,307.2	3,359,616.2	33.8
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	7,596,770.4	1,881,847.5	24.8
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	-	-	-
	Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага	2,329,536.8	1,477,768.7	63.4
2.1	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	-	-	-
	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	-	-	-
	Халамжийн сан	4,800.0	1,200.0	25.0
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	1,969,795.1	1,429,718.7	72.6
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	354,941.7	46,850.0	13.2
	Улсын төсөвт төвлөрүүлэх орлого	-	-	-
<b>3</b>	<b>Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг</b>	<b>543,243.9</b>	<b>543,243.9</b>	<b>100</b>
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	543,243.9	543,243.9	100
	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	-	-	-
3.2	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	-	-	-
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд	-	-	-
	Хөрөнгө оруулалтын зардалд	-	-	-
	Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	-	-	-
3.3	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	-	-	-
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд	-	-	-



Усан хангамжийн татаас	-	-	-
4. Тусгай сангуудын зарлага	860,239.7	-	-
4.1 Сумдын сум хөгжүүлэх сан	860,239.7	-	-

## 2.Өргөн хэрэглээний барааны үнэ:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2022 -I	2023 - I	2023 -I 2022 -I
<b>1.ХҮНСНИЙ БАРАА</b>				
1	Талх, гурил, будаа	1 500	2 200	146.7
	Гурил /Алтантараи, I зэрэг, кг/	1 500	2 200	146.7
	Талх /орон нутгийн, ш/	1 400	2 000	142.9
	Нарийн боов /кг/	4 300	5 500	127.9
	Будаа /кг/	3 200	3 600	112.5
	Элсэн чихэр /кг/	3 200	3 500	109.4
2	<b>МАХ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН</b>			
	Хонины мах /кг/	9 800	9 000	91.8
	Үхрийн мах /кг/	11 500	11 500	100.0
	Адууны мах /кг/	8 500	8 500	100.0
	Ямааны мах /кг/	8 500	8 000	94.1
	Дотор мах, цувдай /цусгүй/	6 000	8 000	133.3
	Хиам /чанасан, кг/	12500	18500	148.0
3	<b>СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ</b>			
	Сүү /задгай, л/	2 500	3 200	128.0
	Сүү /савласан, л/	3 800	4 500	118.4
	Тараг /задгай, л/			
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	21 000	25 000	119.0
	Айраг /л/			
	Хуурай сүү /кг, Өрос, 25% тослогтой/	5 500	8 000	145.5
	Өндөг /ш/	450	450	100.0
4	<b>Бүх төрлийн өөх тос</b>			
	Ургамлын тос /л/	8 150	11 500	141.1
	Өөхөн тос /кг/	3 000	3 000	100.0
	Шар тос /кг/	25 000	25 000	100.0
	Масло /задгай, кг/	6 000	11 000	183.3
5	<b>ХҮНСНИЙ НОГОО</b>			
	Төмс /кг/	1 100	1 500	136.4
	Лууван /кг/	2 500	2 000	80.0
	Манжин /кг/	2 500	2 500	100.0
	Байцаа /кг/	2 800	2 800	100.0
	Сонгино /кг/	2 500	3 000	120.0
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	6 000	6 800	113.3
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	4 000	5 500	137.5
<b>2.ШАТАХУУН</b>				
	Бензин А - 80	2 345	2 480	105.8
	Бензин А - 92	2 345	2 500	106.6
	Дизелийн түлш	2 890	3 910	135.3

## Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 8 агентлагийн ХАСХОМ мэдүүлэх үүрэгтэй 456 албан тушаалтны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд цахимаар гаргуулан баталгаажуулж, Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.

Мөн бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 86.6 хувь, Гэрч хохирогчийг хамгаалах туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрийн биелэлт 95.0 хувийн гүйцэтгэлтэйгээр үнэлүүлж, тайланг Хууль зүй Дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

**Архивын тасаг:** Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагчийн 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу хийгдсэн хяналт шалгалтын мөрөөр Сант, Сайхан, Сүхбаатар, Орхон сумдын Засаг даргын Тамгын газруудад улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлсэн.

“Өргөн Сэлэнгэ үйлчилгээ ОНӨААТҮГ, Хушаат сумын Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, Шаамар, Сайхан сумын Ерөнхий боловсролын сургууль, Мандал сумын Хэрх тосгоны 5 дугаар цэцэрлэг, 1 дүгээр сургуулийн хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх талаар, Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газар, Шаамар сумын Ерөнхий боловсролын сургуулийн архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтанд ХН-д ЭШТБ /хадгаламжийн нэгжийг үдэж хавтаслах/, баримт бичгийн стандартын талаар, Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газрын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтанд ХН-д ЭШТБ /хадгаламжийн нэгжийг үдэж хавтаслах/ талаар арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан.

Ерөө сумын Бугант тосгоны захирагчийн албаны хөмрөгийн 1978-1985 оны 66 ХН, аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 1993-2013 оны 47 ХН-ийн бүртгэлийн мэдээллийг E-document төрийн архивын системд шивж оруулсан. Түнхэл тосгоны Захирагчийн албаны 1974-1975 оны 53 ХН-д иж бүрэн нягтлан шалгалтын ажлыг хийсэн.

Шаамар сумын Ерөнхий боловсролын сургуулийн хэвлэмэл хуудсыг хянаж, хэвлүүлэх зөвшөөрөл олгосон.

Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд “Хөтөлийн цемент шохой” ТӨХК, Ерөө сумын Бугант тосгоны Захирагчийн албаны нийт 13 ХН-ийн 805 хуудас баримтын агуулгыг уншиж заалт 816, хүний нэр 4241, газар зүйн нэр 562, байгууллагын нэр 83 шивж эх баримттай холбох ажлыг хийсэн.

Иргэдийн хүсэлтийн дагуу архивын баримтаас лавлагаа олгох ажлын хүрээнд нийт давхардсан тоогоор 300 гаруй иргэнд үйлчилж, цахим болон цаасан суурьтай баримтаас архивын хуулбар 154, магадалгаа, тодорхойлолт 19, цалингийн лавлагаа 1 тус тус гарган үйлчилж, гаргасан хуулбарыг тухай бүр бүртгэлд бүртгэн ажилласан.

**Цагдаагийн газар:** 2023 оны 02 дугаар сард аймгийн хэмжээнд нийт 936 гомдол мэдээлэл бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 307 буюу 48.8 хувиар өссөн, Үүнээс гэмт хэргийн шинжтэй 318 бүртгэгдсэн нь урд оны мөн үеэс 77 буюу 32.0 хувиар өссөн бол Зөрчлийн 618 гомдол мэдээлэл бүртгэгдэж урд оны мөн үеэс 230 буюу 59.3 хувиар өссөн.



Нийт 130 гэмт хэрэг бүртгэгдэж, урьд оны мөн үеэс 41 буюу 24.0 хувиар буурсан бол нийт 9192 зөрчил бүртгэгдэж, урд оны мөн үеэс 3908 буюу 74.0 хувиар өссөн.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх чиглэлээр “Сар шинэ 2023” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж ажилласан.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар:** “Халтираагүй орчин, хариуцлагатай байгууллага” арга хэмжээг зохион байгуулж, 11 байгууллага, хуулийн этгээдийг хамруулж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үйл ажиллагааны талаар мэдээллийг өгч, иргэдийн ая тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлэн ажиллалаа. Мөн “Хуулиа дээдэлж, үүргээ биелүүлье, хүүхдийн тэтгэлэг, хүүхдийн ирээдүй аян”-г зохион байгуулж олны танил хүмүүсээр иргэдэд урилга хүргүүлж, дуу дүрс бичлэг хийж, олон нийтэд хүргэх зорилгоор цахим сүлжээнд байршуулсан. Аяны хүрээнд хуримтлал үүссэн 5 хүүхдийн тэтгэлэгт ажиллагаа явуулж, 27.0 сая төгрөгийг тэтгэлэг авагчид олголоо.

Нийт 844 төлбөрийн болон хүүхдийн тэтгэлгийн материалд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулж, 105 материалыг дуусгавар болгож, хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ авагдсан 189 ялтан этгээдэд хяналт тавьж, 11 11 хүний хяналт нэмэгдэж, 14 хүний хяналт дуусгавар болж, одоо 186 ялтан этгээдэд хяналт тавин ажиллаж байна.

**Шүүх шинжилгээний хэлтэс:** 2023 оны 02 дугаар сард гэмт хэрэг, зөрчлийн 52 дуудлагад Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллаж, мөрдөгчийн тогтоолоор 67 удаагийн шүүх эмнэлгийн шинжилгээ хийж, үүнээс хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ 50, цогцост задлан шинжилгээ 17, мөн криминалистикийн 7, тусгай шинжилгээ 5 хийж, гарын хээний дардас 89, шүүх гэрэл зураг 2995 /үүнээс шинжилгээний 304, хэргийн газрын үзлэгийн 1835, цоцгосны үзлэг, задлан шинжилгээний 536, бусад 310-ыг боловсруулж ажилласан.

**Улсын бүртгэлийн хэлтэс:** 2023 оны 02 дугаар сарын иргэний бүртгэлийн талаар

- Төрсний бүртгэл - 136 /эрэгтэй-67, эмэгтэй-69/
  - Гэрлэлтийн бүртгэл - 24
  - Гэрлэлт цуцалсны бүртгэл - 15
  - Үрчлэлт - 4
  - Эцэг, эх тогтоолт - 03 /үүнээс эрэгтэй - 1, эмэгтэй - 2/
  - Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл - 8
  - Нас баралт - 57
  - Нийт олгосон иргэний үнэмлэх - 316
  - Шинээр олгосон иргэний үнэмлэх - 97
  - Дахин олгосон иргэний үнэмлэх - 51
  - Иргэний үнэмлэхийн хугацаа дуусаж авсан - 168
  - Гадаад паспорт олголт - 340
  - Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн - 165
  - Хот доторх шилжилт хөдөлгөөн - 513 тус тус бүртгэгдсэн байна.
- Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн талаар:
- Хүлээн авсан мэдүүлгийн тоо - 702
  - Анхны бүртгэл - 331

- Өмчлөх эрх шилжих гэрээ - 101
- Барьцааны гэрээ - 231
- Бүртгэлд өөрчлөлт оруулах - 24
- Лавлагаа хуулбар - 10
- Нийт бичигдсэн гэрчилгээний тоо - 395

Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө, өмчлөх эрхийн улсын бүртгэлийн талаар:

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо - 562
- Анхны бүртгэл - 42
- Өмчлөх эрх шилжих гэрээ - 109
- Барьцааны гэрээ - 353
- Бүртгэлд өөрчлөлт оруулах - 13
- Лавлагаа хуулбар - 15

#### **Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:**

**Боловсрол, соёл урлаг, спортын талаар:** 2022 оны гүйцэтгэлийн үнэлгээнд 34 сургуулийн 1017 багш хамрагдан 20 судлагдахуунаар суралцагчид бичгийн шалгалт өгсөн бөгөөд нийт 505 багш урамшуулалд хамрагдсан байна. Бага ангийн 7 судлагдахуунаар 422 багш гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдаж 223 багш, дунд ахлах ангийн 595 багшаас 282 багш индексийн 1-4-р түвшинд хамрагдан урамшуулал авч байна.

2022-2023 оны хичээлийн жилд төрөлжсөн хичээлийн олимпиадын 2,3-ын давааг зохион байгуулах удирдамжийг ерөнхий боловсролын сургуулиудад хүргэн ажилласан.

ОХУ-ын Боловсролын яамнаас гадаадад орос хэл сурах, заахад дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны хүрээнд Монгол Улсын ерөнхий боловсролын сургуульд орос хэлний хичээл зааж байгаа багш нарыг мэргэжил дээшлүүлэх нэмэлт хөтөлбөрийг В.Г.Короленкогийн нэрэмжит “Глазовскийн Улсын багшийн дээд сургууль” түшиглэн хэрэгжүүлэх гэж байна. Сэлэнгэ аймгаас хамрагдах 6 багшийн мэдээллийг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн.

Бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд унших арга зүйд тулгуурлан бүх шатны боловсролын байгууллагын багш нар, салбарын удирдах ажилтнууд болон судлаачид, мэргэжилтнүүд, ажилтнуудын англи хэлний унших, бичих, ярих, сонсох, хэлний хэрэглээний чадварыг богино хугацаанд хөгжүүлэхэд чиглэсэн “ENGLISH READING TEACHERS-2023” “Боловсролын салбарынханд зориулсан хөгжлийн хөтөлбөр”-т хамгийн олон буюу Сэлэнгэ аймгийн боловсролын салбараас 536 хүн оролцохоор бүртгүүлээд байна.

ISO14001 стандартад суурилсан ОУ-ын эко сургууль хөтөлбөрийн Үндэсний VII дахь чуулганд сургууль, цэцэрлэгүүдийн 102 багш, удирдлагын хамт оролцон “Эко сургууль, цэцэрлэг-Сэлэнгэ аймагт” сэдэвт илтгэл тавьж, ололт, амжилт, туршлагаасаа хуваалцлаа. Тус чуулганаар “Ногоон туг” өргөмжлөлийг 2 сургууль, 5 цэцэрлэг, “Мөнгөн гэрэгэ”-г 5 цэцэрлэг, “Хүрэл гэрэгэ”-г 4 цэцэрлэг авч амжилтаа үнэлүүлээ.

2022-2023 оны хичээлийн жилийн хими, биологи, газар зүйн төрөлжсөн олимпиадын 2,3-ын давааг зохион байгуулах удирдамжийг сургуулиудад хүргүүлэн,

өмнөх оны олимпиадын сэдэв, бодлого болон нэмэлт мэдээллийг багш нарт хүргэн ажиллалаа.

Засгийн газрын 2022 оны “2023-2025 оныг Монголд зочлох жил болгон зарлах тухай” 264 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах, Сэлэнгэ аймагт өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын өвлийн эвент арга хэмжээтэй болох зорилгоор “Замд гаръя-эрүүл агаар-идэвхтэй хөдөлгөөн” цасны баярын өдөрлөг зохион байгуулсан. Өдөрлөгийн арга хэмжээнд 7 төрлийн шалгаруулалтаар 22 албан байгууллагын 360 гаруй ажилтан албан хаагч, иргэд оролцсон.

Тус арга хэмжээнд олон угсаатны өв соёл, зан заншил, урлаг, түүхийн агуулгаар отог урц, үндэсний хувцас хэрэгсэл шалгаруулж, сээр цохих тэмцээн уралдааныг шинээр санаачлан явуулсан нь аялал жуулчлалын салбарын брэнд бүтээгдэхүүн үүсэх эхлэл болсноороо онцлог юм.

Их жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит XXXXIV дэх удаагийн бөхийн чөлөөт барилдааны өсвөр үеийн тэмцээнд ОХУ-ын Зугалай клуб, ОХУ-ын Зэд район болон Дархан, Орхон, Өмнөговь, Сүхбаатар, Говь-Алтай, Архангай, Баянхонгор, Булган, Дорноговь, Төв, Хөвсгөл аймгуудын 33 байгууллагын баг тамирчид, 591 тамирчин оролцож, авхаалж самбаа хурд хүчээ сорин өрсөлдлөө.

XVII жарны үзэсгэлэн болгогч хэмээх усан туулай жилийн Сар шинийн баярт зориулсан Улс, аймгийн цолтой үндэсний бөхийн барилдаанд нийт 64 бөх барилдсанаас Улсын арслан Э.Оюунболд, Улсын арслан Р.Пүрэвдагва, Улсын заан Н.Жаргалбаяр, Улсын начин Н.Баярбаатар нар шөвгөрч Улсын заан Н.Жаргалбаяр түрүүлж, Улсын арслан Р.Пүрэвдагва үзүүрлэлээ. Тус барилдааны үеэр Сэлэнгэ аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж ахмад Бөхчүүд, Уяачид, Үндэсний сурын харваа Үндэсний шагайн харваачдад хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг гардууллаа.

Ерөө суманд өсвөр болон залуучуудын сумо бөхийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулагдаж тус тэмцээнд 12 сум 4 тосгоны нийт 16 багийн 226 өсвөрийн залуучуудын сумочид оролцлоо.

Өсвөрийн шатарчдын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, 12 сумын 8 клуб, сургуулиудын 239 шатарчин хүүхдүүд оролцлоо. Тус тэмцээнээс 7 насны 14 ангилалд эхний нийт 28 хүүхэд Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрх, 12 насны эрэгтэй, эмэгтэй тус бүр нэг нэг хүүхэд тус наадамд оролцох эрхээ авлаа.

**Эрүүл мэндийн талаар:** Алслагдсан хүн ам, малчин өрх, отор нүүдлээр яваа иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүргэх үүднээс “Халуун сэтгэл-2023” үзлэг, оношилгоог Хүдэр, Түшиг суманд зохион байгууллаа. Үзлэгт аймгийн Нэгдсэн эмнэлэг, Ерөө, Хүдэр, Цагааннуур, Сайхан, Баянгол, Зүүнбүрэн сумд, Мандал сумын Хэрх тосгоны эрүүл мэндийн төвүүд, “Ачит амирлуулагч” эмнэлгийн нийт 32 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, Хүдэр сумын Засаг даргын Тамгын газрын ажилтан, албан хаагчид ажилчид нийт 55 гаруй хүний бүрэлдэхүүнтэй баг суурин болон явуулын хэлбэрээр иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлсэн.

Сумын эрүүл мэндийн төвд байрлан сумын төвийн иргэдэд 4 төрлийн нарийн мэргэжлийн эмчийн тусламж үзүүлж 2 өдөрт нийт 143 үзлэг, оношилгоог хийсэн байна.

Алслагдсан хүн ам, малчин өрх, отор нүүдлээр яваа иргэдэд явуулын 2 баг 782 гаруй км замыг туулан 3 төрлийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, 2 төрлийн оношилгоо (зүрхний цахилгаан бичлэг, эхо)-г нийт 474 иргэнд үзүүлэн ажиллалаа.

Нийт 266 өвчлөлийг илрүүлэн, эмчилгээ зөвлөгөө өгч ажилсан ба шинээр 42 өвчлөлийг илрүүлсэн.

Иргэдийн дунд зонхилон тохиолдож буй тэргүүлэх 5 өвчлөлд:

1. Зүрх судасны эрхтэн тогтолцооны өвчлөл - 46.9 хувь
2. Бөөр шээсний замын эрхтэн тогтолцооны өвчлөл - 19.5 хувь
3. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчлөл - 16.3 хувь
4. Мэдрэлийн эрхтэн тогтолцооны өвчлөл - 3.7 хувь
5. Шүдний өвчлөл - 18.4 хувь
6. Хүүхдийн амьсгалын замын өвчлөл - 9 хувь
7. Амьсгалын эрхтэн тогтолцооны өвчлөл - 3.2 хувийг тус тус эзэлж байна.

Мөн явуулын багт эмийн сангийн үйлчилгээг үзүүлж, 2.1 сая төгрөгийн эмийг бөөний үнээр зарж борлуулсан байна.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь Улсын Нийгмийн даатгалын Ерөнхий газраас 5,370,367,900 төгрөгийн санхүүжилт хүлээн авсан.

Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 3896757.71 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл оруулах төлөвлөгөөтэйгөөс 3836234.72 мянган төгрөг хуримтлуулж төлөвлөгөөний биелэлт 98.45 хувьтай байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 18849 тэтгэвэр авагчдад 9789082.04 мянган төгрөгийг олголоо.

Тэтгэмжийн даатгалын сангаас 508 даатгуулагчдад 339673.1 мянган төгрөгийн Хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн болон амаржсаны, оршуулгын тэтгэмж олгосон.

ҮОМШӨ-ний даатгалын сангаас 173 даатгуулагчид 99390.55 мянган төгрөгийн тэтгэвэр, ҮО-ийн тэтгэмж, сувиллын зардалд олгосон байна.

Ажилгүйдлийн даатгалын сангаас 68 даатгуулагчдад 184253.53 мянган төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгосон.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь 2 дугаар сард 5 удаа хуралдаж нийт 370 иргэн даатгуулагчид эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйлчилгээг үзүүлж 31 иргэнд шинээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг тогтоож, 93 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг сунгаж 305 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ хугацааг цуцалсан байна.

Нийт 21 аймаг, 9 дүүргийн нийгмийн даатгалын 1995-2005 оны 40 лавлагааны хүсэлтийг хүлээн авч 36 лавлагааг гарган хугацаанд нь хүргүүллээ. Мөн аймаг дотроо 43 иргэд даатгуулагчаас лавлагааны хүсэлтийг авч нийт 83 лавлагааг хугацаанд гаргаж ажиллалаа.

**Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, нийгмийн даатгалын хүрээнд:** Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж хөнгөлөлтийн үйлчилгээг зорилтот бүлэгт түргэн шуурхай, хүнд сурталгүй чанартай хүргэх ажлын хүрээнд Улсын төсвийн орлогоос Халамжийн санд улсын төсвөөс тайлант хугацаанд 63779 иргэнд 11144047.8 мянган төгрөг, Орон нутгийн төсвийн орлогоос 3 иргэнд 3600.0 мянган төгрөгийг олголоо.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэхээр дараах үйлчилгээг иргэдэд үзүүллээ. Үүнд:

Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан EJOB программд баяжилт хийж:

- Ажил олгогчийн мэдээлэл - 30

- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд - 6 иргэн
- Идэвхтэй ажил хайгчаар - 91 иргэн
- Ажил зуучлах үйлчилгээнд - 32 иргэн
- Сул чөлөөтэй 45 ажлын байрыг бүртгэж мэдээлсэн байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг ганцаарчилсан болон бүлгийн хэлбэрээр 6 иргэнд үзүүлсэн байна.

**Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар:** “Уран жиргээ-2023” аймгийн аварга шалгаруулах уран уншлагын наадмыг зохион байгууллаа. Наадамд сургуулийн өмнөх нас ба цэцэрлэг, сургуулийн бага, дунд, ахлах насны ангилалд 15 сумын 145 уран яруу уншигч хүүхэд багачууд оролцсоноос уран унших чадвараараа тэргүүлсэн 12 хүүхэд шагналт байранд шалгарлаа.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд 02 дугаар сарын байдлаар 11 дуудлага бүртгэгдсэн ба орон нутгаар нь ангилахад ХЭУБ 1, Сүхбаатар 2, Мандал 3, Хушаат 2, Хүдэр 1, Сайхан 1, Шаамар тус тус бүртгэгдэж дуудлага мэдээллийг хамтарсан багуудад шилжүүлэн мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллалаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 2 удаа хуралдаж нийт 23 хүүхдийн асуудлыг шийдвэрлэн ажиллалаа.

Аймгийн Хамтарсан багийн нарийн бичгийн дарга, сумдын нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн, нийгмийн ажилтнуудад “Кейс менежмент арга зүй” сургалтыг зохион байгуулж нийт 50 албан хаагч хамрагдлаа.

“Эерэг сэтгэлгээ” сургалтыг 2 байгууллагын 60 албан хаагчдын дунд зохион байгууллаа. Цахим залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагааг 2 байгууллагын 25 албан хаагчдад сурталчиллаа.

#### **Тав. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хүрээнд:**

**Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр:** Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Цагааннуур сумын “Баянсэлэнгэ” ХХК-ий захирал Я.Идэрнамнан Монгол Улсын “Гавьяат Агрономич” цол тэмдгээр, Түшиг сумын “Бооцын тариа” ХХК-ий захирал С.Баатар Монгол Улсын “Гавьяат механикжуулагч” цол тэмдгээр тус тус шагнагдлаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 134 дүгээр тогтоолын дагуу 2022 оны ажлын үзүүлэлтээр “Аймгийн аварга фермер”, “Аймгийн аварга малчин” шалгаруулах журмын хүрээнд 16 сумаас 13 фермер, 27 малчны материалыг хүлээн авч аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцэн журамд заагдсан шалгуур үзүүлэлт, материалын бүрдүүлэлт хангалтгүй шалтгаанаар 7 фермер, 2 малчны материалыг буцааж, 6 фермер, 25 малчны материал шаардлага хангасан гэж үзэн шалгаруулсан.

Аймгийн Засаг даргын 2023 оны А/51 дүгээр захирамжаар “Малчдын зөвлөгөөн-2023” арга хэмжээг тариалангийн бүс нутагт мал аж ахуй эрхлэх таатай боломж нөхцөлийг хэлэлцэх, малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэн эрчимжүүлэх, эрүүлжүүлэх, малчдад мал аж ахуйн талаар баримтлах бодлого, зорилтыг танилцуулах, мал аж ахуйн тогтвортой хөгжлийг хангах зорилготой Мал эмнэлгийн газар, “Хөгжлийн шийдэл” ТББ-ын “BEST хөтөлбөр”-тэй хамтран зохион байгууллаа.

Зөвлөгөөнд 17 сумын Засаг дарга, сумдын Засаг даргын Тамгын газрын хөдөө аж ахуйн тасгийн дарга, 350 гаруй малчдын төлөөлөл хамрагдсан.



Аймгийн Засаг даргын 2023 оны А/61 дүгээр захирамжийн дагуу “Цагаан сар-2023” үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа. Үзэсгэлэн худалдаанд 11 сумын 64 аж ахуйн нэгж, иргэдийн 100 гаруй нэр төрлийн төмс хүнсний ногоо, жимсгэнийн чанамал, өтгөрүүлсэн шүүс, сүү цагаан идээ, хэвийн боов, зөгийн бал, даршилж савласан ногоо, эмийн ургамал, ургамлын цай, гар урлал, давсан урлал, бэлэг дурсгал, сүлжмэл ноосон эдлэл, арьс, ширэн эдлэл, гутал, модон эдлэл зэрэг бүтээгдэхүүнтэйгээр оролцож нийт 38,585,000 төгрөгийн борлуулалт хийгдсэн байна.

Жижиг, дунд үйлдвэрийн газар, “Хөгжлийн шийдэл” ТББ-ын “Бэйст хөтөлбөр”-тэй хамтран Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан болон Хоршоо хөгжүүлэх сангаас олгох хөнгөлөлттэй зээл, төсөл боловсруулах талаар зөвлөгөө мэдээллийг өгөх сургалтыг зохион байгуулж, сургалтад 30 гаруй жижиг, дунд үйлдвэр эрхлэгч оролцлоо.

Урьдчилсан дүнгээр малын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан болох [livestock.mofa.gov.mn](http://livestock.mofa.gov.mn)-д 5262 өрхийн мэдээллийг шивж оруулан 48 хувийн гүйцэтгэлтэй явж байна.

**Мал эмнэлгийн чиглэлээр:** Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын улсын Ерөнхий байцаагчийн 2023 оны “Нийтээр тэмдэглэх баяр болон цаг үеийн шаардлагаар зохион байгуулж буй арга хэмжээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” 08-00/01 удирдамжийн дагуу 17 сумын МЭТ-ийн улсын байцаагч нар “Сар шинэ”-ийн баяртай холбогдуулан урьдчилан сэргийлэх мал эмнэлгийн хяналт, шалгалтыг мал, амьтны гаралтай түүхий эд ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, борлуулдаг газруудад хийлээ.

Сүхбаатар сумын хэмжээнд хүнсний зах, дэлгүүрт худалдан борлуулж байгаа мах, махан бүтээгдэхүүний 6240 кг үхрийн махны 52 дээж, 2688 кг хонины махны 120 дээж, 1407 кг ямааны 67 дээж, 810 кг адууны 9 дээж, 240 кг сүү, сүүн бүтээгдэхүүний 9 дээж нийт 257 дээжид ариун цэврийн магадлан шинжилгээг стандарт арга зүйн дагуу хийж гүйцэтгэсэн.

Хушаат сумаас 1 эмгэгт дээжид нян судлалын шинжилгээ хийж УМЭАЦТЛ-д хариуг баталгаажуулахаар хүргүүлсэн. Сүхбаатар сумын 4 дээжид ийлдэс судлалын шинжилгээ хийж 1 сорьц дээжид хачгийн халуун өвчний эсрэг биет илэрч, хариуг Мал эмнэлгийн газрын дарга, ерөнхий эмчээр баталгаажуулан малчин, мал бүхий иргэнд хүргүүлж цахим системд бүртгэсэн.

Сүхбаатар сумын 2 адууны дээжид шимэгч судлалын шинжилгээ хийж *Strongylus equines*-ийн өндөг илэрч Мал эмнэлгийн лабораторийн цахим систем [/vetlab.shinjilgee.mn](http://vetlab.shinjilgee.mn)-д 54 хандалтын 227 сорьц дээжийг бүртгэсэн байна.

Орон нутгийн 17 сумын МЭТ-ийн улсын байцаагч, тархвар зүйч нартай цахим хурал зохион байгуулж улсын хэмжээнд гоц халдварт өвчний дэгдэлт, тархалтын цаг үеийн байдал, тандалт судалгааг зохион байгуулах, мал эмнэлгийн хяналт шалгалтыг яаралтай зохион байгуулах талаар мэдээлэл өгч, санал солилцож үүрэг чиглэл өгч ажиллалаа.

**Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр:** Хүдэр, Ерөө, Мандал сумдын ойн сангийн талбайд хүрээлэн буй орчны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэсэн. Хүдэр, Хушаат зэрэг суманд Биотехникийн ажлыг гүйцэтгэлийг шалгасан. Үүнд: Хүдэр суманд 3 хэсэг газар 300 кг хужир, 50 ширхэг боодлын өвс, Хушаат суманд 2 хэсэг газар 200 кг хужир, 60 ш боодлын өвс

зэргийг буулгаж хэсэгчлэн зарим газарт цасан бүрхүүлийг арилгаж зэрлэг ан амьтныг мараанд орох нөхцөлийг бүрдүүлэх зэрэг ажлуудыг үе шаттайгаар үргэлжлүүлэн хийж байна.

**Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын чиглэлээр:** Хүүхэд залуучуудын парк барих газрын байршлыг судлах ажлын хүрээнд Алтанбулаг сум 3 дугаар баг Сайханы хөтөл явах зам дагуух газрыг судлан 40 га газрыг сонгон тус сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд оруулж ажиллалаа.

Сумдын 2023 оны газрын албан татвар ногдуулалтыг хүчинтэй төлөвт байгаа 28326 нэгж талбарт үүсгэснээс 16078 нэгж талбарт нэхэмжлэл, 15 сумын 18649 хүчинтэй төлөвтэй гэрээнд ногдуулалт, 14121 нэгж талбарт нэхэмжлэл үүсгэн Татварын удирдлагын нэгдсэн системд илгээж, системээс газрын төлбөр, татварын төлөлтийн мэдээллийг хүлээн авах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Газрын кадастрын мэдээллийн системд 15 сумын газрын төлбөр ногдуулалт, төлөлтийн мэдээллийг нягтлах, газрын кадастрын мэдээллийн сантай тулгах, шалгах, нөхөн оруулах, засварлах ажлыг зохион байгуулан сумдын газрын даамлуудыг арга зүйн зөвлөмж чиглэлээр ханган ажиллаж байна.

Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай хүсэлт гаргасан 13 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийн дагуу аймгийн Засаг даргын 2 удаагийн захирамжаар 5443 м.кв газрын эзэмших эрхийг шилжүүлсэн. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д зааснаар 5 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээнд Э дугаар авах хүсэлтийг дундын мэдээллийн сангаар дамжуулан Улсын бүртгэлийн хэлтэст илгээж, газар эзэмших эрхийн гэрээ, гэрчилгээг шинэчилсэн байна.

Газар эзэмших эрхийн гэрчилгээг банк болон санхүүгийн байгууллагад барьцаалах хүсэлтийн дагуу 17 иргэний 17 нэгж талбарын газар эзэмших эрхийн гэрчилгээнд бүртгэл хийж, 7 нэгж талбарын эзэмших эрхийн гэрчилгээг барьцаанаас чөлөөлсөн. Газар эзэмших эрхийн гэрчилгээгээ нэгтгэх хүсэлт гаргасан иргэний хоёр нэгж талбарт байрлах 258 м.кв газрыг газрын кадастрын мэдээллийн системд нэгтгэж, аймгийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэсэн.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Цагааннуур суманд Сити нойл” барих ажлыг “Баяжих ундрага” ХХК гүйцэтгэж, Засгийн газрын 2021 оны 212 тогтоол “Барилга байгууламжийг ашиглалтад хүлээлцүүлэх дүрэм”-ийн дагуу Улсын комисс ажиллаж, үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээлцүүлсэн.

**Орон нутгийн өмчийн чиглэлээр:** Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим системд байршуулан Зууны мэдээ сонины 2022.12.20 № 246 (6978) тоот дугаарт нийтлүүлэн нээлттэй ил тод мэдээлсэн.

Мөн 17 сумдын 2023 оны бараа ажил үйлчилгээний төлөвлөгөөг хянан баталгаажуулж Сангийн яаманд хүргүүлсэн.

Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тоот тогтоол, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/260 тоот тушаалаар батлагдсан “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам” батлагдаж журмын дагуу аймгийн Засаг даргын захирамжийн төслийг боловсруулан ажиллаж байна.

## Зургаа. Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:

### Алтанбулаг сум:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 02/114 тоот “Автозам, тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангуулах болон урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах” албан тоотын дагуу эвдэрч хаагдах, нурах эрсдэлтэй зам, гүүр болон гол нуурын мөс цөмрөх газруудын судалгааг гаргаж түүгээр тээврийн хэрэгсэл явуулахгүй байх, мөн Гүн нуур, Хярааны голын шинээр ашиглалтад орсон бетон гүүр, Хондын гарам, Гялаан нуур зэрэг газруудад анхааруулах самбар байршуулсан.

Сумын Засаг даргын 2023 оны “Сумын нэгдсэн спортын тэмцээн уралдаан, соёл урлагийн арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” А/07 тоот захирамжийн дагуу “Мөнгөн өвөл” сумын цасны баярын арга хэмжээг зохион байгуулагдаж нийт 10 баг оролцлоо.

Сумын засаг даргын ивээл дор XVII жарны “Үзэсгэлэн болгогч” хэмээх харагчин туулай жилийн “Сар шинийн баяр”-т зориулсан өсвөрийн залуу бөхчүүдийн “Бөхийн гараа” нэртэй сумын аварга шалгаруулах үндэсний бөхийн барилдааныг зохион байгуулж, сургуулийн насны 1-2 дугаар анги, 3-4 дүгээр анги, 5-6 дугаар анги, 7-9 дүгээр анги, 10-12 дугаар анги гэсэн 5 насны ангиллаар өсвөрийн залуу 114 бөх барилдаж, түрүүлж, үзүүрлэсэн, их шөвгийн дөрөвт шалгаран үлдсэн бөхчүүд болон уран гараа дэвээтэй, уран барилдаантай өсвөрийн залуу бөхчүүдэд өргөмжлөл медалиар шагнаж урамшууллаа.

Сумын Засаг даргын 2023 оны “Ахмад настанд хүндэтгэл үзүүлэх тухай” А/16 дугаар захирамжийн дагуу Цөх 3 дугаар багийн иргэн Чойжавын Цэвэл, өндөр настан 92 нас сүүдрийг зооглож буй Бүргэдэй 1 дүгээр багийн иргэн Данзангийн Арьяажав нарт Алтанбулаг сумаас сонгогдсон аймгийн иргэдийн хурлын төлөөлөгч С.Чойсүрэнгийн хамт сумын Засаг дарга Н.Отгонцогт сар шинийн баярын хүндэтгэл үзүүлж аймаг, сумын Засаг даргын гарын бэлгийг гардууллаа.

БНСУ-ын “НК” группийн ерөнхийлөгч Лий Хун Ко-той Алтанбулаг суманд аялал жуулчлалыг хөгжүүлэх, зам, дэд бүтэцийг сайжруулах, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд хөрөнгө оруулалт хийж хамтран ажиллах талаар харилцан санал солилцох уулзалтыг Дархан-уул аймгийн “Ажил олгогч эздийн холбоо”-ны тэргүүн Д.Соёлтуяагийн дэмжлэгтэйгээр зохион байгууллаа.

### Баруунбүрэн сум:

Сумын “Малчдын зөвлөгөөн-2023” арга хэмжээг Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж нийт 220 гаруй малчин оролцлоо. 2022 оны ажил хөдөлмөрөөрөө төрд үнэлэгдсэн дараах малчид, иргэдэд шагналуудыг гардуулан өглөө. Тус зөвлөгөөнөөр аймгийн Мал эмнэлгийн газрын дарга С.Ариунтөгс, Малын Удмын сангийн Үндэсний төвийн Үйлдвэрлэл хариуцсан захирал Н.Бархас нарыг урилгаар оролцож малчдад зөвлөгөө өгч, илтгэл тавилаа.

Мөн зөвлөгөөний үеэр “Цагаан сар-2023” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж хувиараа үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч иргэд үзэсгэлэн гаргаж, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ, сургууль, цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоолны амталгаа, номын сангийн үйлчилгээ, малын эмийн худалдаа, халуун усны үйлчилгээг малчдад үзүүллээ.

Хаврын тэргүүн сарын “Үзэсгэлэн болгогч хэмээх усан туулай” жилийн сар шинийн баяр болохтой холбогдуулан Үндэсний бөхийн барилдааныг зохион байгууллаа.

Төр, төсвийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг идэвхжүүлэх зорилгоор “Мөнгөн өвөл” цасны баярыг зохион байгууллаа. Цасны баярт нийт 6 багийн 30 тамирчин оролцлоо.

#### **Баянгол сум:**

Аймгийн хэмжээнд анх удаа “U14” насны ангиллаар аймгийн аварга шалгаруулах гар бөмбөгийн нээлттэй тэмцээнийг зохион байгуулж нийт 33 багийн 300 гаруй тамирчид хурд хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө.

“Тогтвортой хөгжлийн боловсрол-2” төсөл, НҮБ-ын суурин зохицуулагчийн газрын дэмжлэгтэйгээр Олон Улсын Эко сургууль, цэцэрлэг хөтөлбөрийн үндэсний 7-р чуулганыг зохион байгуулж “Ногоон туг”-ийг гардан авлаа.

Сар шинийн баярыг угтаж “Дээлтэй Монгол” өдөрлөг арга хэмжээг сумын Соёлын төвтэй хамтран зохион байгуулж 9 бүлгийн 105 эцэг эх хамрагдаж шагайн харваа, шагай шүүрэх, шагай няслах, морь уралдуулах, алаг мэлхий өрөх зэрэг тэмцээнүүд зохион байгууллаа.

XVII жарны “Үзэсгэлэн болгогч” хэмээх харагчин усан туулай жилийн сар шинийн баярын “Амар мэндийн аялгуу” хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулж сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газраас 75-аас дээш насны ахмадуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүллээ.

Сумын Эрүүл мэндийн төвтэй хамтран 7-12-р ангийн хөвгүүдийн дунд “Архи тамхи”, “Электрон тамхи”-ны хор уршиг талаар сургалтад 16 бүлгийн нийт 132 суралцагч, “Алхам алхмаар” аяны хүрээнд 8-12 дугаар ангийн сурагчдад өөрийгөө таних, ирээдүйн ажил мэргэжлээ сонгоход нь туслах зорилготой “Мэргэжил сонголтод эцэг, эхийн оролцоо” өдөрлөгийг төгсөх 12 дугаар ангийн эцэг эхийн дунд, НТБ-ын нэгжийн багш О.Баярхүү “Мэргэжил сонголт-Бид” сэдэвт сургалтыг 8-12 дугаар ангийн нийт 235 хүүхдүүдийн дунд тус тус зохион байгууллаа.

Малчин эмэгтэйчүүдийн холбооны Баянгол сумын салбар зөвлөлтэй хамтран “Малчин эмэгтэйчүүд” уулзалтыг зохион байгуулж “Хаврын найраг” хүндэтгэлийн тоглолт, нийтийн бүжгийн арга хэмжээг “Баянголын эмэгтэйчүүд” бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн үзэсгэлэн, “Хөдөө аж ахуйн алдартнууд” гэрэл зураг, Д.Төртөвшингийн “Хөрөг” хайчилбарын үзэсгэлэн, шинэ номын үзэсгэлэнг зохион байгуулж, 350 иргэн хамрагдсан.

Монголын эмэгтэйчүүдийн холбооны Баянгол сумын салбар зөвлөл, Ахмадын хороотой хамтран “Ээжийн чанасан цай” соёлын эвент үйл ажиллагаа 2023.02.19-ний өдөр явагдаж нийт 350 хүн хамрагдлаа.

#### **Ерөө сум**

Дархан-Уул аймагт зохион байгуулагдсан Газрын багц хууль, Геодези, зураг зүйн тухай болон Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар төрийн болон төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаачид, иргэд олон нийтийг хамруулсан хэлэлцүүлэгт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 3 төлөөлөгч, Засаг даргын Тамгын газрын 2 албан хаагч хамрагдлаа.

Сумын Засаг даргын 2023 оны “Хүндэтгэл үзүүлэх тухай” А/22 дугаар захирамжаар 75-84 настай 63 ахмад настан болон 2022 оны ажил хөдөлмөрөөрөө

тэргүүлсэн сумын аваргуудад, 50-аас дээш настай аймаг, сумын цолтой бөхчүүд, харваач, алдарч уяач 28 иргэнд хүндэтгэл үзүүллээ.

Суманд үйл ажиллагаа явуулдаг нийт 48 аж ахуйн нэгж, байгууллага 447 ахмад настанд хүндэтгэл үзүүлж 24,3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Сумын Засаг даргын 2023 оны А/10 дугаар захирамжийн дагуу Хүнсний аюулгүй байдлыг хангах, нийтийг хамарсан хоол хүнсээр дамжих өвчин гарахаас урьдчилан сэргийлэх, бараа бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах зорилгоор суманд худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 10 аж ахуй нэгж байгууллагад төлөвлөгөөт хяналт, шалгалтыг зохион байгуулж, илэрсэн зөрчлийг тухай нь цаг хугацаанд арилгуулж, заавар зөвлөмж, хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан.

“Ерөөлтэй цагаан сар-2023” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, 14 иргэн, 2 аж ахуй нэгж 52 төрлийн бараа, бүтээгдэхүүнээр оролцож 6.400.000 төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Спорт цогцолбортой хамтран “Хүчит бөхийн барилдаан”-ыг зохион байгуулж, тус арга хэмжээнд нийт 32 бөх оролцлоо.

Албан хаагчдын эрүүл мэнд, хөдөлгөөнийг дэмжих, нийгэм соёлын оролцоог идэвхжүүлэх зорилгын хүрээнд “Идэвхтэй хөдөлгөөн-Эрүүл амьдралын үндэс” уриа дор “Цасны баяр-2023” арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд 10 байгууллагыг хамруулсан нийт 6 баг оролцлоо.

Шинээр ашиглалтад орсон Цэцэрлэгийн үйл ажиллагаатай холбогдуулан аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газраас сургалтын хэрэгцээнд 3.554.798 төгрөгийн төсөвт өртөг бүхий суурин компьютерын хөрөнгө оруулалт хийгдсэн. Мөн эцэг, эхчүүдээс санаачилсан хандиваар 3 бүлэгт зурагт, тоос сорогч, хөшиг, хөшиг тогтоогч, шалавч, аяганы тавиур, хогийн сав, цэцгийн сав зэргийг нийт 7.113.000 төгрөгийн өртгөөр худалдан авсан.

#### **Жавхлант сүм:**

Сумын ахмад настан аймгийн алдарт уяач, сумын сайн малчин Иваны Бат-Очир Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн дээд “Алтан гадас” одонгоор шагнагдлаа.

Монголын уламжлалт “Сар шинийн баяр”-ын өдрийг тохиолдуулан Ахмад настны тухай хуульд заасны дагуу аж ахуйн нэгж, байгууллага бүр ажиллаж байсан болон сумын 70-аас дээш настай нийт 294 ахмад настнуудад хүндэтгэл үзүүллээ.

2022 оны ажлын үр дүнгээрээ манлайлан ажилласан аймаг, сумын ажил мэргэжлийн аваргуудыг шалгаруулан шагналыг гардуулан өгсөн.

Аймгийн “Чөлөөт бөх”-ийн өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээнд 7 тамирчин сурагч амжилттай оролцож 1 алт, 3 хүрэл медаль хүртлээ.

Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэн “Авьяслаг Жавхлантчууд-2023” урлагийн наадмыг 8 төрлөөр зохион байгууллаа. Тэргүүн байранд М.Батжаргал даргатай Моностой 2-р баг шалгарч шилжин явах цомоор, дэд байранд С.Оюунчимэг эрхлэгчтэй 1-р цэцэрлэгийн хамт олон тус тус шалгарлаа.

Жавхлант сумын хөгжлийн төлөө Эрүүл мэндийн салбарт баримтлан ажиллаж буй бодлого зорилтуудыг амжилттай хэрэгжүүлж, хүн ардынхаа эрүүл мэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ, хэвтэн эмчлүүлэгсдийн ая тухтай байдал, сэтгэл ханамжид анхааран ажилласан Эрүүл мэндийн төвийн хамт олны хөдөлмөр



зүтгэлийг үнэлэн Эрүүл мэндийн төвийн хамт олон 4 дэх удаагаа “Тэргүүний хамт олон”-оор шалгарлаа.

#### **Зүүнбүрэн сум:**

Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор, Ч.Ундрам, Ж.Эрдэнэбат нар иргэдтэй уулзалт хийж Улсын Их Хурлын үйл ажиллагааны тайлан, цаг үеийн асуудлаар уулзалт хийсэн уулзалтад давхардсан тоогоор 580 иргэн оролцсон.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны ээлжит хуралдаанаар Сумын засаг даргын 2021-2024 оны “Өрхийг дэмжих өсөлтийн бодлого” үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө, Зүүнбүрэн сум байгуулагдсаны 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсэг байгуулах тухай болон бусад хэлэлцүүлэхээр өргөн барилаа.

Сумын ахмад настнуудад Улсын Их Хурлын аймгаас сонгогдсон гишүүд, аймаг, сумын Засаг даргатай хамтран хүндэтгэл үзүүллээ.

#### **Мандал сум:**

Сумын төр, төсвийн байгууллагын албан хаагчдын дунд “Төрийн албан хаагчдын зөвлөгөөн-2023” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж 170 гаруй төрийн албан хаагчдын хамрагдлаа. Зөвлөгөөнд урилгаар Удирдлагын академийн эрх зүйн тэнхимийн ахлах багш С.Ганцэцэг “Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаанд төрийн албаны тухай болон хөдөлмөрийн хуулийг хэрэглэх тухай”, Эмэгтэйчүүдийн залуучуудын оюуны сан, үндэсний сүлжээ ТББ-ын тэргүүн Ц.Бүжидмаа “Шинэ зууны манлайлал” сэдэвт лекц, сургалтыг явуулж мэдлэг олгосон.

Зөвлөгөөнөөр төрийн албанд тасралтгүй ажилласан төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний 15 албан хаагчийг шагнаж урамшууллаа.

“Зөвлөлдөж шийдье” зөвлөлдөх санал асуулгын хэмжээний зөвлөлдөх санал асуулгын хоёр дахь шатны уулзалтад 11 хүн оролцлоо.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Эрдэнэбат Мандал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 11,12 дугаар ангийн сурагчидтай уулзалтыг зохион байгуулж, уулзалтаар мэргэжил сонголтын талаар санал солилцон мэргэжил сонголтын чиглэлээр дэлхийн тэргүүн туршлага бүрийг багтаасан зөвлөмж, сорилго, өмнөх оны элсэлтийн ерөнхий шалгалтын сорилго тест бүхий “Шинэ алхам” номыг гардуулан өгч шалгалтад амжилт хүслээ. Мөн хуульч, лектор Ц.Азбаяр ахлах ангийн сурагчдад зориулан “Өөрийгөө хэрхэн таних, яаж тодорхойлох, юу чаддаг цаашид ямар мэргэжлийг өөрийнхөө хүсэл сонирхол чадварт тулгуурлан хэрхэн сонгох” зэрэг арга барилыг танилцууллаа. Уулзалтад аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж, сумын Засаг дарга А.Дашзэвэг, Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 500 гаруй сурагч, хүүхэд багачууд оролцлоо.

Мандал сумын “Адуучдын холбоо”-оос “Морьтны гоёл-2023” наадмыг Монгол мориороо бахархах, дээдлэх, өв соёлыг уламжлал болгон өвлүүлэх зорилгын хүрээнд зохион байгууллаа. Наадамд аймгийн 5 сум, Төв аймгийн 2 сумдаас 60 адуучид ирж оролцлоо.

“Сар шинийн баяр”-ыг тохиолдуулан 85-аас дээш насны 105 ахмад настанд аймгийн Засаг даргын гарын бэлгийг гардууллаа.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 91 дүгээр тогтоолоор “2023 онд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар хэрэглээний мод болон түлээ бэлтгэх, ойжуулалт хийх 28 нөхөрлөл, 23 аж ахуйн нэгж, байгууллагад хэрэглээ

19976,6 м3, түлээ 13711,4 м3 буюу нийт 33688 м3 мод бэлтгэлийн хуваарь баталсан. Хуваарийн дагуу 22 аж ахуйн нэгж, байгууллага, 10 нөхөрлөлтэй гэрээ байгуулж 2023 оны мод бэлтгэлийн үйл ажиллагааг эхлүүлээд байна.

Мод бэлтгэлийн талбай тусгаарлалт хийлгэх 6 аж ахуй, нэгж байгууллага хүсэлт гаргасны дагуу үйлдвэрлэлийн огтлолтоор 42 га, цэвэрлэгээний огтлолтоор 66 га 8 цэгт 108 га талбайд тусгаарлалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Мод бэлтгэлийн үйл ажиллагааг эхлүүлснээр 12 аж ахуй нэгж байгууллага 2108.9 м3 хэрэглээ, 678.6 м3 түлээ, 5 аж ахуй нэгж байгууллагын ойн сангаас 27 иргэнд 239 м3 түлээний мод бэлтгэх эрхийн бичгийг тус тус олгож 11,8 сая төгрөгийг төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн.

Улаанбаатар төмөр замын Мод бэлтгэлийн үйлдвэрийн 54 м3 хагалсан түлээ, 3 аж ахуй нэгж байгууллагын 34 м3 хэрэглээний модонд тус тус гарал үүслийн гэрчилгээг олгосон.

Сар шинийн баярыг угтан “Монголд үйлдвэрлэв-2023” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж 33 иргэн, аж ахуйн нэгж, нөхөрлөл, хоршоодын 120 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг дэлгэн тавьж 25.1 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн. Тус үзэсгэлэн худалдаанд Улаанбаатар хот болон Дархан-Уул аймгаас худалдаа эрхлэгчид ирж оролцлоо.

#### **Орхон сум:**

Улсын Их Хурлын гишүүн Ж.Эрдэнэбат тус сумын иргэд, олон нийттэй уулзаж санал санаачилгыг сонсохын зэрэгцээ “Халуун сэтгэл-2023” явуулын эрүүл мэндийн үзлэг, оношилгоог зохион байгуулж давхардсан тоогоор 544 иргэн хамрагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор сумын иргэд олон нийттэй уулзалт зохион байгуулж, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч мөн өөрийн ажлын тайлан мэдээг танилцуулж ажиллалаа. Тус уулзалтад 215 иргэн оролцлоо.

“Орхонд үйлдвэрлэв” сар шинийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдаж, тус үзэсгэлэн худалдаанд 18 төрлийн бүтээгдэхүүн оролцож, нийт 3.318.000 төгрөгийн борлуулалт хийгдлээ. “Хамгийн олон төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч”-ээр иргэн М.Отгонцэцэг, “Шилдэг бүтээгдэхүүн”-ээр иргэн н.Пүрэвжав, “Хамгийн их борлуулалт хийсэн номинаци”-аар иргэн А.Сумъяа, Т.Ууганбаяр нар тус тус шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа.

Сумын Засаг даргын 2023 оны “Нийтийг хамарсан тэмцээн, уралдаан зохион байгуулах тухай” А/05 дугаар захирамжийн дагуу иргэдийн эрүүл, идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих зорилгоор “Цасны баяр”-ын арга хэмжээг зохион байгуулж төр, төсвийн байгууллага, иргэдийн 7 баг оролцлоо. Арга хэмжээний хүрээнд үндэсний уламжлалт өв соёл, зан заншил, тоглоом наадгайг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Уламжлалт өв соёлоо дээдэлъе” тэмцээнд 5 баг оролцлоо.

Үзэсгэлэн болгогч хэмээх харагчин усан туулай жилийн сар шинийн босгон дээр хөдөлмөр, зүтгэлээ төр, түмэндээ үнэлүүлэн төрийн дээд одон “Алтан гадас”-аар 6 иргэн шагнагдлаа. Мөн сумын шилдгүүдээ шалгаруулж, шагнаж урамшууллаа.

#### **Орхонтуул сум:**

Улсын Их Хурлын гишүүн Ж.Эрдэнэбат, Д.Өнөрболор иргэдтэй уулзах уулзалтыг зохион байгуулж 250 иргэн, төр, төсвийн байгууллагын албан хаагчдыг хамруулсан.

Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд мал, амьтны гоц халдварт бог малын мялзан, хонь ямааны цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгын хүрээнд

иргэдэд гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх холбогдох заавар, зөвлөмж сэрэмжлүүлгийг сумын цахим хуудсаар болон малчдад биечлэн очиж танилцуулах ажлыг хийж цагийн байдлын мэдээг тогтоосон цагт хүргэн ажилласан.

Баянцогт 2-р багийн орон сууцны хорооллын автомашины зогсоолыг бүрэн шийдэж сумын хэмжээнд Цагдаагийн байгууллагатай хамтран “Яараад яахав”, “Намайг алгас” аяны хүрээнд иргэдэд гарын авлага болон сургалт сурталчилгааг хийж уг арга хэмжээнд нийт 65 иргэн 5 аж ахуйн нэгж хамрагдсан байна.

Мөн 3 байршилд замын тэмдэг тэмдэглэгээг шинжлэн байршуулж, нийтийн хог цэвэрлэгээг 2 удаа зохион байгуулж төвлөрсөн хогийн цэгийг түрж тэгшлэх ажлыг хийлээ.

#### **Сайхан сум:**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны А/243 тоот “Хоршоо хөгжүүлэх сангийн журам”, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны “Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах тов тогтоох тухай” 39 дүгээр тогтоолын дагуу “Сонгон шалгаруулах зөвлөл”-ийн шийдвэр, сумын Засаг даргын 2023 оны “Хоршоо хөгжүүлэх сангийн зээл санхүүжүүлэх тухай” А/20 дүгээр захирамжаар нийт 7 иргэний төслийг 105 сая төгрөгийг санхүүжүүлэн ажиллалаа.

XVII жарны “Үзэсгэлэн болгогч” хэмээх харагчин туулай жилээ угтаж сумын төр, төсвийн байгууллагууд, аж ахуй нэгж, худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн дунд 2 “Нүүдэлчин өв соёл-2023” урлагийн наадмыг зохион байгууллаа.

“Цагаан сар-2023” үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, оролцогчид 11 сая төгрөгийн борлуулалт хийсэн.

2022 оны сумын аварга болон шилдэг байгууллага шалгаруулах арга хэмжээ, мөн сар шинийн баярт зориулсан Улс, аймгийн алдар цолтой 48 бөхийн барилдааныг зохион байгууллаа.

Галын аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, сумын хэмжээнд гарч буй гал түймрийн тоо, хохирлыг бууруулах, гэр хорооллын айл өрхүүдэд гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар үзлэг шалгалт зохион байгуулж, цахилгаан, пийшин, зуух, яндангийн аюулгүй байдлын стандарт, норм, нормативыг мөрдүүлэх, галын аюулгүй ажиллагааны зааварчилгааг таниулах, олон нийтэд өргөн хүрээтэй сурталчлах зорилгоор Гал түймэр унтраах, аврах 61 дүгээр анги болон “ДСЦТС” ХК-ий ХӨТӨЛ салбартай хамтран “Сар шинэ-2023” нэгдсэн арга хэмжээг Овоот, Жимстэй, Дөмбөн хорооллын 131 айл өрхийг хамруулан зохион байгууллаа.

“Осол гэмтлээс сэргийлэх” өдрийг тохиолдуулан “Хүүхэд аюулгүй орчин” сарын аяныг Эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгуулж аж ахуйн нэгж байгууллагуудын дунд болон 9-12 ангийн 60 сурагчдад Дархан-Уул аймгийн Цагдаагийн газрын сэтгэл зүйч, Цагдаагийн дэслэгч С.Дөлгөөнзаяа “Хүүхэд аюулгүй орчин” сэдвээр сургалт, зөвлөгөө мэдээлэл хүргэн аюулгүй орчныг бүрдүүлэх, аюул ослоос урьдчилан сэргийлэх сургалтыг 1-12 ангийн 305 сурагч, 30 эцэг эх, асран хамгаалагч нарт зохион байгууллаа.

#### **Сант сум:**

Улсын Их Хурлын гишүүн Ж.Эрдэнэбат аймгийн Засаг даргын орлогч Ж.Сайнцог, Эрүүл мэндийн газрын дарга Ж.Од нарын хамтаар сумын иргэд, албан хаагчидтай уулзалт хийлээ. Тэрээр цаг үеийн бодлого шийдвэр, мэдээ мэдээлэл тэр дундаа хүүхдийн мөнгө, шаталсан татварын тогтолцоо, төрийн захиргааны албан

хаагчдын цалингийн нэмэгдэл, хөрөнгө оруулалт зэрэг асуудлаар тодорхой бодит мэдээллийг хүргэж иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч сонслоо.

Цагаан сарын баярыг тохиолдуулан сумын 70-аас дээш настай ахмадуудад Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам, Д.Өнөрболор, 85-аас дээш настай ахмадуудад аймгийн Засаг даргын хүндэтгэл болох гарын бэлгийг сум, орон нутгийн удирдлагууд гардууллаа. Нийт 70-аас дээш насны 73 ахмад настан хамрагдсан байна.

Сумын “Малчдын зөвлөгөөн”-ийг зохион байгуулж малчин, мал бүхий 157 иргэд хамрагдлаа. Зөвлөгөөнд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Б.Мөнхтөр, Мал эмнэлгийн газрын дарга С.Ариунтөгс, Малын удмын сангийн үндэсний төвийн генийн сангийн эрхлэгч Д.Жамбацадимад, ТЕГ-ын Сэлэнгэ аймаг дахь газрын дэд дарга Мягмаржав нар урилгаар оролцож “Сэлэнгэ аймгийн мал аж ахуйн салбарын өнөөгийн байдал, цаашдын зорилт”, “Малын гоц халдварт өвчин, нөхцөл байдал, анхаарах асуудал”, “Малын чанар сайжруулах, ашиг нэмэгдүүлэхэд биотехнологийн дэвшилтэд аргыг ашиглах нь” сэдвээр илтгэл мэдээлэл тавилаа.

Орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, борлуулалтыг дэмжих, туршлага солилцох, нэг дороос худалдан авалт хийх иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангах зорилгоор “Үйлдвэрлэгч-Үндэсний баялаг” үзэсгэлэн худалдааг суманд зохион байгууллаа. Үзэсгэлэн худалдаанд 2 төсвийн байгууллага, 5 аж ахуйн нэгж, 12 иргэн 53 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож шилдгүүдийг шалгаруулж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.

Монголын Үндэсний радиогийн “Таван эрдэнэ” нэвтрүүлгийн нэрэмжит “Алтан тугалын эзэн”-ээр Бадарчийн Жаргалцогт, Арьяагийн Даваасүрэн нар шалгарч сум, орон нутгийнхаа нэрийг алдаршууллаа.

Сар шинийн баярт зориулсан “Үндэсний бөхийн барилдаан”-ыг зохион байгуулж 32 бөх барилдсанаас аймгийн заан Б.Ганбаяр түрүүлж, аймгийн заан Б.Эрдэнэбаяр үзүүлэн, аймгийн начин П.Алтанхуяг, сумын заан Б.Лхагваа нар шөвгөрлөө. Үндэсний бөхийн барилдааныг Б.Баттөмөр захиралтай “Шинэ эхлэл” ХХК ивээн тэтгэлээ.

Аймгийн аварга шалгаруулах “НАРТ” сумо бөхийн тэмцээнд 22 сурагч оролцсоноос 1 алт, 1 мөнгө, 1 хүрэл медаль авч багаараа “Дэд байр” эзэлсэн амжилтыг үзүүллээ. Мөн аймгийн аварга шалгаруулах “Чөлөөт бөх”-ийн тэмцээнд 28 сурагч оролцож 1 алт, 6 мөнгө, 6 хүрэл нийт 13 медаль хүртэж багаараа “Гутгаар байр”-д шалгарлаа.

“Уран жиргээ” аймгийн аварга шалгаруулах уран уншлагын уралдаанд ахлах ангийн төрөлд 10А ангийн суралцагч Ж.Энхжин оролцож “Тэргүүн байр”-д шалгаран улсын уралдаанд оролцох эрхтэй боллоо.

#### **Сүхбаатар сум:**

Улсын Их Хурлын гишүүн Ж.Эрдэнэбат, Д.Өнөрболор нарын иргэдтэй уулзах уулзалтыг зохион байгуулж уулзалтаар Улсын Их Хурлаас хийж хэрэгжүүлж байгаа ажлын талаар болон тойрогтоо чиглэсэн ажил үйлчилгээний талаар мэдээлэл өгч иргэдийн асуултад хариулт өгөн, санал солилцон ажилласан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор 1, “Цэргийн гавьяаны одон”-оор 1, “Алтангадас одон”-оор 15, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар 5, “Соёлын тэргүүний ажилтан”-аар 2, “Эрчим

хүчний тэргүүний ажилтан"-аар 1, "Үйлвэрлэл, худалдаа, үйлчилгээний тэргүүний ажилтан"-аар 1 тус тус шагнагдсан.

"МАСАМ-2" төслийн хүрээнд Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг сайжруулах "Сайн эмнэлэг-Сэтгэлд нийцсэн үйлчилгээ" аргачлалыг Сүхбаатар суманд хэрэгжүүлэх баг ажиллаж тус сумын Эмнэх баг өрхийн эрүүл мэндийн төвд материаллаг орчны, сэтгэл зүйн орчны, засаглалын орчны үнэлгээ гэсэн 3 төрлөөр 3 хэсэг ажлын баг гарган үнэлгээ хийж, материаллаг орчны үнэлгээгээр 90,2 оноо, сэтгэл зүйн орчны үнэлгээгээр 89,6 оноо, Засаглалын орчны үнэлгээгээр 89,2 оноо авч үнэлэгдэн цаашид хэрэгжүүлэх ажлын зөвлөмж өгч хамтран ажилласан.

Мөн "Сайн эмнэлэг-Сэтгэлд нийцсэн үйлчилгээ" аргачлалыг түгээн дэлгэрүүлэх сургалт зохион байгуулагдаж, сургалтад сумын иргэдийн Хурлын Төлөөлөгч, тус сумын өрхийн Эрүүл мэндийн төвийн эрүүл мэндийн ажилтан, сумын нийгмийн бодлогын мэргэжилтэн, багийн Засаг дарга нар, багийн хэсгийн ахлагч, 1 болон 7-р цэцэрлэгийн эмч, сумын иргэний төлөөллүүд хамрагдсан.

Дархан-Уул аймагт зохион байгуулагдсан "Гэрээр айлчлагч" хөтөлбөрийн сургалтад багийн Засаг дарга, Нийгмийн ажилтан нар, мөн аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучууд хөгжлийн газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төлөө "Галт шувуу" ТББ-тай хамтран зохион байгуулсан "Кейс менежмент" хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалтад тус сумын 8 багийн нийгмийн ажилтан хамрагдлаа.

Аймгийн Засаг даргын сар шинийн гарын бэлгийг тус сумын 85-аас дээш насны 77 ахмад настанд, аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас харьяалалгүй 560 ахмад настанд, сумын Засаг даргын сар шинийн гарын бэлгийг 75-84 насны харьяалалгүй 530 ахмад настанд гардуулах ажлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, сумын Засаг дарга болон багийн Засаг дарга нартай хамтран зохион байгуулан олгож хүндэтгэл үзүүлсэн.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор, Ж.Эрдэнэбат, Ч.Ундрам нар сар шинийн баярыг тохиолдуулан тус сумын ахмад настнуудад гарын бэлэг болон 1530 ширхэг гурил өгснийг сумын харьяалалгүй ахмадуудад өглөө.

#### **Түшиг сум:**

Төрийн албан хаагчдын "Нэгдсэн зөвлөгөөн"-ийг зохион байгуулж, "Хөрөнгө оруулалтын ажлын үр дүн, цаашдын төлөвлөгөө", "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, анхаарах асуудлууд", "Цалин хөлсний шинэчлэлт", "Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаа" зэрэг мэдээллийг холбогдох мэргэжилтнүүд хүргэлээ. Мөн төрийн албан хаагчдын дунд "Спортын нөхөрсөг тэмцээн"-ийг Гар бөмбөг, Сагсан бөмбөг, Ширээний теннис, Олс таталт, Буухиа тэмцээний төрлүүдээр явуулж давхардсан тоогоор 80 гаруй төрийн албан хаагчид оролцлоо. Арга хэмжээний хүрээнд

- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Хүндэт өргөмжлөл"-өөр Ерөнхий боловсролын сургуулийн багш Д.Оюунтуяа, Э.Батцоож
- Аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр Санхүүгийн албаны дарга Б.Батдэлгэр, Нийгмийн бодлогын мэргэжилтэн Д.Цэрэнноров, Ерөнхий боловсролын сургуулийн багш Б.Мөнхнаран нар шагнагдлаа.

Аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй хамтран малчин өрхүүдийн иргэдэд эрүүл мэндийн үзлэг, оношилгоо хийх "Халуун сэтгэл" аяныг зохион байгуулж, 120 өрхийн 250 гаруй иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлж ажиллалаа.



2022 онд мал аж ахуй, газар тариалангийн салбарт амжилт гаргасан сумын аваргуудыг тодруулж шагнаж урамшууллаа. Үүнд:

- “Аварга тариаланч”-аар “Гацуурт” ХХК-ий тариаланч С.Гэндэнжамц
  - “Аварга малчин”-аар Б.Хүрэлбаатар
  - “Өрхийн үйлдвэрлэгч”-ээр Д.Баатарсүрэн
  - “Аварга ногоочин”-оор Д.Чулуунхүү, Т.Таня нар
  - Сумын “Алдарт уяач”-аар А.Амараа, Б.Баттүшиг, Д.Батсайхан, Ч.Авирмэд
- Сар шинийн баярын арга хэмжээний үеэр:
- “Соёлын тэргүүний ажилтан”-аар Соёлын төвийн хөгжмийн багш В.Бүрэнтөгс, Номын санч Л.Баярцэцэг, Орон нутаг судлах танхимын ажилтан Л.Халиун нар
  - Соёлын яамны “Жуух бичиг”-ээр үйлчилгээний ажилтан Б.Өнөрсайхан нар шагнагдлаа.

Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг иргэдэд тайлагнаж танилцуулах иргэдийн уулзалт арга хэмжээг зохион байгуулж нийт 126 иргэн оролцлоо. Мөн тайлангийн эмхэтгэл сэтгүүлийг нийт 450 өрхөд тарааж, тайланг цахим хуудсанд байршууллаа.

Сар шинийн баярын өдрийг тохиолдуулан 85-аас дээш насны ахмад настан В.Сэр-Од-д аймгийн Засаг даргын гарын бэлгийг гардуулж, 70-аас дээш настай 49 ахмад настанд сумын Засаг даргын гарын бэлгийг гардуулж, хүндэтгэл үзүүллээ.

Цагдаагийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, орон нутгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүднээс Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт 28.0 сая төгрөгөөр автомашин худалдан авч хүлээлгэн өглөө.

Сумын Засаг даргын 2023 оны А/11 тоот захирамжаар орон гэр нь гал түймэрт өртсөн Арнуга 2 дугаар багийн иргэн А.Алтансүхийн гэр бүлд Засаг даргын нөөцийн хөрөнгөөс 500.0 мянган төгрөгийг олгож, Улаан загалмайн анхан шатны хорооноос мөн 500.0 мянган төгрөг, дулаан хувцас хэрэгсэл, хүнсний тусламжийг үзүүллээ.

#### Хушаат сум:

“Цагаан сар-2023” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж үйлдвэрлэгч өрхийн 9 иргэн оролцож нийт 2,156,000 төгрөгийн борлуулалт хийсэн.

Бог малын мялзан, хонь ямааны цэцэг өвчний гаралт тархалт буурахгүй байгаатай холбогдуулан гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх заавар зөвлөмжийг мэдээллийн хэрэгслээр тогтмол хангаж ажилласан.

2-р багийн малжуулах төсөлд хамрагдах боломжтой бага малтай малчин өрхийн судалгааг гаргаж танилцуулахад бэлэн болгон ажиллаж байна. Ар урт гэх газрын малчин Ц.Наянтайн хотонд чоно дайрсан дуудлага мэдээг хүлээн авч газар дээр нь нөхцөл байдалтай танилцан чононоос дээж аван аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлэн чоно болон түүнд хазуулсан тэжээвэр нохой, хонь ямааг устгаж ажилласан.

#### Хүдэр сум:

Аймгийн Засаг даргын 2023 оны 01/56 дугаар албан бичиг болон бусад холбогдох хууль тогтоомж, шийдвэрүүдийн дагуу алслагдсан хүн ам, малчин өрх, отор нүүдлээр яваа иргэдэд “Халуун сэтгэл-2023” нүүдлийн эрүүл мэндийн үзлэг, оношилгоог зохион байгуулан ажиллалаа. Тус үзлэгт аймгийн Нэгдсэн эмнэлэг, Ерөө, Сайхан, Баянгол, Зүүнбүрэн сумд, Мандал сумын Хэрх тосгоны Эрүүл

